



БАЯНХОНГОР АЙМГИЙН
БАЯНЦАГААН СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2024 оны 10 сарын 25 өдөр

Дугаар 2/04

Баянбулаг

г Сумын 2025-2028 оны Засаг даргын үйл
ажиллагааны хөтөлбөр хэлэлцэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.5, 35.1.8, 48 дугаар зүйлийн 48.1, 52 дугаар зүйлийн 52.1.2, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.11.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчийн Хурлын ээлжит II хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Сумын 2025-2028 оны Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.

2.Сумын 2025-2028 оны Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг сүм хөгжүүлэх төлөвлөгөөнд тусгаж, хэрэгжилтийн явцыг 2 жил тутамд, ИТХ-ын хуралдаанаар хэлэлцүүлж ажиллахыг сумын Засаг дарга (Н.Гансүх)-д үүрэг болгосугай.



648803173

Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ...
оны 12 сарын 25-ны өдрийн II
хуралдааны 104 дугаар тогтоолын хавсралт

БАЯНЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН 2025-2028 ОНД
ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБОР

2024 оны 12 дугаар сарын 25

Баянбулаг

ЭРХЭМ ЗОРИЛГО: Бүтээлч чадвартай мэргэшсэн ажиллах хүчинээр хангагдсан, унаган байгаль, экологийн тэнцвэрийг хадгалж, байгаль орчныхоо онцлогт зохицсон, эрчимжсэн хедөө аж ахуй, үйлдвэрлэл хосолсон, худалдаа үйлчилгээ хөгжсөн, "Хүний хөгжлөөрөө тэргүүлсэн-Хөдөө аж ахуйн жишиг сум" болох зорилгын хүрээнд:

Нийтлэг үндэслэл: Сумын Засаг даргын 2025-2028 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулахдаа Монгол улсын Засгийн газрын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Аймгийн Засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Баянхонгор аймгийг 2025-2028 онд хөгжүүлэх хэтийн зорилт, Баянцагаан сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө, 2024 оны орон нутгийн Сонгуульд дэвшүүлсэн Ардчилсан намын мериин хөтөлбөр зэрэг бодлогын баримт бичгүүдийг үндэслэл болгон эдийн засаг, нийгмийн хүндрэлийг амжилттай даван туулж, хүн ам, нийгмийн хөгжлийг хангах байгаль орчны тэнцвэртэй байдал, засаглалыг сайжруулах төрийн бодлогын залгамж чанарыг хадгалахад онцгойлон анхаарч дараах 9 бүлэг багц асуудлын хүрээнд хэрэгжүүлэх зорилго, зорилтуудаа дэвшүүлж байна.

Нэг . ХҮНИЙ ХӨГЖИЛ

1.1. Зорилго: Хөгжсөн иргэн -Хөгжлийг бүтээнэ.

1.1.1 Баянцагаан сумын иргэдийн хөгжил төлөвшил манлайлал, мэдлэг, мэдээллийг нэмэгдүүлэх зорилгоор жил бүр нэгдсэн чуулга уулзалт зөвлөгөөнүүдийг зохион байгуулах.

1.1.2 "Хамтарсан баг" –ийн үйл ажиллагааг дэмжиж иргэдрүү чиглэсэн бодлого хэрэгжүүлнэ.

1.1.3 Нийтийн биеийн тамирыг хөгжүүлнэ.

1.1.4 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, ажлын байр нэмэгдүүлж, ядуурлыг бууруулна.

Хоёр. БОЛОВСРОЛ

Зорилго 1.1 Боловсролын чанар –Хөгжлийн тулгуур

2.1.1 Боловсролын байгууллагын материаллаг баазыг нэмэгдүүлнэ

2.1.2 Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын чанарыг сайжруулж, стандарт хангалтыг нэмэгдүүлнэ

2.1.3 Хонгорын хүүхэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ

2.1.4 "Хос бичигтэн сум" сумын дэд хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.

Гурав. ЭРҮҮЛ МЭНД

Зорилго 3.1: Эрүүл иргэн -Ирээдүйн үнэт зүйл

- 3.1.1 Эрүүл мэндийн байгууллагын материаллаг баазыг нэмэгдүүлнэ
- 3.1.2 Эрчүүдийн эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлнэ
- 3.1.3 Сумын хүн амын өсөлтийг бодлогоор дэмжинэ.
- 3.1.4 Хүн амыг урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээ, эмчилгээнд тогтмол хамруулна.
- 3.1.5 Иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох сургалтыг тогтмол зохион байгуулна.

Дөрөв. СОЁЛ, УРЛАГ СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ САЛБАР

Зорилго: Соёлтой иргэн –Нийгмийг түүчээлнэ

Зорилт 4.1 Соёл урлагийн бодлого

- 4.1.1 Соёл урлагийн байгууллагын материаллаг баазаар хангана.
- 4.1.2 Иргэдийн удмын санг хамгаалах, угийн бичиг хөтлөлтийг идэвхжүүлэх, түгээн дэлгэрүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ
- 4.1.3 Амарбуянт бүсийн онцлогтой урлаг, соёлын биет болон биет бус үнэт өвийг хамгаалах, орон нутаг судлах танхимын бүтээгдэхүүн үзмэрийг баяжуулах, сурталчлан таниулах ажлыг бодлогоор дэмжинэ
- 4.1.4 Үндэсний соёлын өв тээгчдийн тоог нэмэгдүүлнэ
- 4.1.5 Мэргэжлийн багш нарын дугуйланг тогтмолжуулж үр дүнг тайлагнасан уран бүтээлийг нийтийн хүртээл болгоно

Зорилт 4.2 Спорт

- 4.2.1 Үндэсний спортын холбоодын үйл ажиллагааг бодлогоор дэмжинэ.
- 4.2.2 Баянцагаан сумын бренд спортын төрлүүдийн хөгжлийг эрчимжүүлэх, дэмжлэг үзүүлэх, амжилт гаргасан тамирчдад урамшуулал олгох журамд нэмэлт өөрчлөлт оруулах
- 4.2.3 Оны аварга шалгаруулах спортын олон төрөлт тэмцээнүүдийг зохион байгуулна

Тав. ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ, ҮЙЛДВЭРЖИЛТ,

ДЭД БҮТЦИЙН БОДЛОГО

Зорилго: Бүтээлч үйлдвэрлэл -Чинээлэг иргэн

Зорилт 5.1 Эдийн засгийн өсөлт, үйлдвэржилт

- 5.1.1 Төсөв санхүүгийн менежментийн тогтвортой байдлыг хангана.

Зорилт 5.2. Дэд бүтцийн бодлого

- 5.2.1 Сум, орон нутгийн инженерийн дэд бүтцийг сайжруулж хөгжлийн бодлогыг тодорхойлно. Нийтийн болон ТАХ-ын орон сууц, хаус хороолол барьж байгуулна
- 5.2.2 Эрчим хүчний эх үүсвэрийн ашиглалтыг сайжруулна
- 5.2.3 Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, эрүүл, аюулгүй орчныг бий болгоно.

**5.2.4 Үүрэн холбооны сүлжээний ашиглалтыг нэмэгдүүлэж, шинээр суурилуулна
Зургаа. ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, БАЙГАЛЬ ОРЧИН
НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО**

Зорилго: Эрүүл мал –Эрүүл хүнс –Эко үйлдвэрлэл

Зорилт 6.1 Хөдөө аж ахуй

- 6.1.1 Хөдөө аж ахуйн салбарын материалаг баазыг нэмэгдүүлнэ
- 6.1.2 Хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний үйлдвэр, цехүүдийг бий болгоно
- 6.1.3 Малчдад зориулсан цогц арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх
- 6.1.4 Хөдөө аж ахуйн чиглэлийн өдөрлөг арга хэмжээнүүдийг тогтмол зохион байгуулна.
- 6.1.5 Бэлчээрийн менежментийн бодлогыг шинэ түвшинд хэрэгжүүлнэ
- 6.1.6 Хоршоодын үйл ажиллагааг бодлогоор дэмжинэ
- 6.1.7 Мал эмнэлгийн аж ахуй нэгжийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэн эрүүл бүс статусаа батална.

Зорилт 6.2 Газар тариалан

- 6.2.1 Тэжээлийн олон наст, ногоон тэжээл тариалалтыг нэмэгдүүлнэ
- 6.2.2 Хүнсний ногоо, жимс жимсгээнийн дотоодын хангамжийг нэмэгдүүлнэ

Зорилт 6.3. Байгаль орчин

- 6.3.1 "Ногоон-Баянцагаан" хөтөлбөр хэрэгжүүлнэ
- 6.3.2 Орчны бохирдлыг бууруулж, хог хаягдлын менежментийг сайжруулна
- 6.3.3 Усны нөөцийг бохирдол хомстлоос хамгаалах, зохистой ашиглах нэгдсэн менежментийг хэрэгжүүлнэ
- 6.3.4 Ховордсон ан амьтдыг хамгаалах нэгдсэн арга хэмжээ зохион байгуулна
- 6.3.5 Сумын аялалын маршрутын зураг гаргаж онцлох газруудад дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлнэ.

**Долоо. ЗАСАГЛАЛ, ГАДААД ХАРИЛЦАА,
НИЙГМИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ**

Зорилго: Ээлтэй засаглал –Эрсдэлгүй амьдрал

Зорилт 7.1 Сайн засаглал, нийгмийн аюулгүй байдал

- 7.1.1 Батлан хамгаалах болон гамшгаас хамгаалах хууль тогтоомжийг орон нутагт хэрэгжүүлнэ
- 7.1.2 Улаан загалмайн анхан шатны хороотой хамтран сургалт мэдээллийг зохион байгуулж, материалыг баазыг бэлтгэнэ
- 7.1.3 Сумын хилийн цэсийн маргааныг холбогдох байгууллагуудтай хамтарч шийдвэрлүүлнэ
- 7.1.4 Төрийн албан хаагчийн хууль, ёс зүйн дүрмийг баримталж ажиллана.
- 7.1.5 Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлнэ

7.1.6 Засаг даргын Тамгын газрын материалаг баазыг нэмэгдүүлэх менежментийг сайжруулах

7.1.7 Дэлгэрэх багийн төвийг шинэчилнэ.

7.1.8 Хүний нөөц, боловсон хүчний хөтөлбөрийн 2-р шатыг хэрэгжүүлнэ.

7.1.9 Нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөтгөж, нийгмийн даатгалын сайн дурын үйлчилгээг даатгуулагчийн эрэлт, хэрэгцээнд нийцуулэн нэмэгдүүлнэ.

**Найм. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ТАТАХ, ХӨРӨНГӨ БОСГОХ ЭХ ҮҮСВЭР БИЙ
БОЛГОХ**

Зорилго: Ашигтай хөрөнгө оруулалт –Оновчтой төлөвлөлт

Зорилт 8.1 хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг орон нутгийн төвшинд татах

8.1.1 Олон улсын төсөл хөтөлбөрийн байгууллагуудтай хамтран ажиллах, малчдын бүлэг, нөхөрлөл, хоршоодыг үйл ажиллагааг дэмжинэ

Ec.ГАДААД ХАРИЛЦАА

Зорилго: Хамтын ажиллагаа -Холч бодлого

Зорилт 9.1 Гадаад харилцааг орон нутгийн түвшинд хөгжүүлэх

9.1.1 Бусад аймаг сумуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэх, улмаар гадаадын улс орнуудтай харилцаж сумд ашигтай хөрөнгө оруулалтуудыг шийдвэрлүүлэх

----ooOoo----